

Монгол улс руу мөнгө шилжүүлэх үед Сошиал орчинд ихэвчлэн ажиглагддаг зүйл нь 「Япон улсад иен аваад, Монгол улсад төгрөг өгнө.Олон улсын мөнгөн гуйвуулга хийх хүсэлтэй хүн байвал холбоо барина уу」 гэх мэт эдгээр нь Япон улсад хууль бус үйлдэл билээ.

Тухайлбал:Монгол улсаас Япон улс руу мөнгө илгээж авмаар байгаа хувь хүн болон Япон улсаас Монгол улс руу мөнгө илгээх хүсэлтэй байгаа хоёр хүн хоорондоо шууд холбогдож хоёр улсын дотоод банкууд тус бүрт шилжүүлэг үйлддэг.Энэхүү үйл ажиллагааг мэргэжлийн хэлээр 「Газар доорх банк」 гэж нэрэлдэг бөгөөд Япон улсын банкны тухай хууль, Гадаад худалдаа, валютын хуулинд заасны дагуу хатуу хориотой байдаг.Банкны хуулинд заасны дагуу зөвшөөрөл аваагүй этгээд мөнгө шилжүүлэгчийн хувийн мэдээллийг шалгалгүйгээр мөнгө илгээх нь хар тамхи, мансууруулах бодис болон терроризмийг санхүүжүүлэх, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдох боломжтой гэж үздэг.

Япон улсад гадаад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг санхүүгийн хороонд албан ёсны бүртгэлтэй банк болон мөнгөн гуйвуулагын компаниас бусад газрууд эрхлэх боломжгүй юм.Япон улсад суугаа Монгол улсын иргэн тус хуулийг зөрчин баривчлагдаж байсан жишээг анхааруулах үүднээс доор орууллаа.

Гүнма аймагт оршин суудаг Монгол улсын иргэн Газар доорх банкаар шилжүүлж авсан бохир мөнгөөр компани байгуулсан хэрэгт сэжиглэгдэн баривчлагдлаа.Гүнма болон Шизүока аймгийн хамтарсан мөрдлөгийн хэлтэс энэ сарын 14-ны өдөр банкны тухай хуулыг зөрчсөн хэргээр зарга үүсгэгдээд байсан Точиги аймгийн Хакаричо-д байрлах Монгол улсын иргэн 35-н настай захирал А-г зохион байгуулалттай гэмт хэргийг зөрчсөн хэргээр дахин баривчилсан.Дээрх хуулийг 10 орчим удаа зөрчсөн бөгөөд байцаалтын үеэр хэргээ хүлээх гээд ирсэн учир дахин баривчлагдлаа, ойлгомжгүй байна хэмээн мэдүүлэг өгөв.

Баривчлагдсан сэжигтэн нь өнгөрсөн жилийн 7 сарын сүүлээс 9 сарын эхэн хооронд хууль бусаар шилжүүлж авсан 700,000 иенийг компанийн дүрмийн сангийн нэг хэсэг болгож автомашины сэлбэг экспортолдог компани байгуулан захирлаар ажиллаж байжээ.Дансанд ойролцоогоор Монгол иргэдээс цуглуулсан 54,500,000 иен байгаа нь тогтоогдсон.Тус сэжигтэн нь хуучин машины сэлбэг худалдан авч Монгол улс руу экспорт хийн олсон орлогоо Монгол улс руу илгээдэг байжээ.

Эх сурвалж: Санкэй мэдээ

<https://www.sankei.com/region/news/170215/rgn1702150071-n1.html>

Газар доорх банкаар дамжуулан олсон орлогоор компани байгуулсан Монгол улсын иргэнийг баривчиллаа. Фүкүрой-ын олон улсын мөрдлөгийн хэлтэс, Гүнма аймгийн мөрдлөгийн хэлтэс 14-ны өдөр банкны тухай хуулыг зөрчсөн хэргээр зарга үүсгэгдээд байсан Точиги аймагт хуучин автомашины борлуулалт эрхэлдэг 35 настай иргэнийг зохион байгуулалттай гэмт хэргийг зөрчсөн хэргээр дахин баривчиллаа.2016 оны 7 сарын сүүлээс 9 сарын эхэн хооронд хууль бусаар шилжүүлж авсан 700,000 иенийг компанийн дүрмийн сангийн нэг хэсэг болгож хуучин

автомашин борлуулдаг компани байгуулан захирлаар ажиллаж байжээ. Тус сэжигтэн нь өөрөө хэргийг үйлдээгүй гэж мэдүүлэг өгсөн.13 жилийн өмнөөс нийт 280 орчим Монгол иргэнээс захиалга авч ойролцоогоор 540 удаа нийт 54,500,000 иен шилжүүлсэн байжээ.Япон улсад дансанд орж ирсэн мөнгөө ашиглан автомашины хуучин сэлбэг худалдан авч Монгол улс руу экспортолдог байжээ.Мөнгөний зөрүү дээрээс ашиг олдог байсан гэж үзэж байна.

Эх сурвалж:Шизуока сонин

<http://www.at-s.com/news/article/social/shizuoka/329157.html>

(2017 оны 2 сарын 15)

Энэ мэтчилэн газар доорх банкаар дамжуулан мөнгө гуйвуулах нь хүнд гэмт хэрэгт тооцогдоно.Япон улсад суугаа Монгол улсын иргэдээ тус хуулийн заалтыг мэдэхгүй байсан эсвэл би ганцаараа учир зүгээр гэж бодох нь хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхгүй юм.Дээрх үйлдлүүд нь Япон улсад сурч, ажил, амьдрал эрхэлж буй Монгол иргэдийн нэр төрд муугаар нөлөөлнө.Япон улсын арилжааны банкнаас гадаад мөнгөн гуйвуулга хийхэд шимтгэл өндөр хэдий ч доор танилцуулсан олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг компаниудийг ашигласнаар бага зардлаар, түргэн шуурхай мөнгө илгээх боломжтой билээ.

Асууж, лавлах зүйл байвал манай төлөөлөгчийн газартай холбоо барина уу.